

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 он ... дугаар сарын  
... өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 11.1.2.в, 11.1.2.г дэд заалтыг тус тус нэмсүгэй:

“11.1.2.в. Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>2</sup>.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр;

11.1.2.г. Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон татварын бус орлого.”

**2 дугаар зүйл.** Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэх дэд заалтын “уул уурхайн олборлолт” гэсний өмнө “энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.2. Хуримтлалын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:”

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 он ... дугаар сарын  
... өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>2</sup> дугаар зүйлийн 47<sup>2.2</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47<sup>2.2</sup>.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын энэ хуулийн 47<sup>2.1</sup>-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”

**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>2</sup> дугаар зүйлийн 47<sup>2.1</sup> дэх хэсгийн “тооцож улсын төсөвт төлнө.” гэснийг “тооцно.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>2</sup> дугаар зүйлийн 47<sup>2.3</sup> дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг